



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/576

Чингис хот

Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1 "г", 30 дугаар зүйлийн 30.1.15, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Үндэсний Статистикийн хорооны даргын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/917 тоот албан бичиг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын ажлыг 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс 17-ны өдрүүдэд явуулсугай.

2. 2021 оны жилийн эцсийн Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Г. Сэдэдмаа	Аймгийн Статистикийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн

Дарга

Гишүүдэд:

Ц.Батхишиг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн/
С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга
Б.Хэрлэнчимэг	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга

281012577

2.

Д.Баярхүү

Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын дарга


3. Жилийн эцсийн мал тооллогод зарцуулах хөрөнгийн тооцоог 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4. Аймгийн жилийн эцсийн мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын хяналтын тооллогын зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

5. Мал тооллогод зарцуулах 11,542,000 (арван нэгэн сая таван зуун дөчин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваад зөвшөөрсүгэй.

6. Жилийн эцсийн мал тооллогын ажлыг халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, сумдын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСOMЖАВ